



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЭДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.07.17 № 490
танай 2024.06.21-ны № 07 -т

ДАШБАЛБАР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДАШБАЛБАР
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА Ж.ЁНДОНЖАМЦ
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Дорнод аймгийн Дашбалбар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Дашбалбар сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817- 6 :2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

011021363

Дүгнэлт

Дорнод аймгийн Дашбалбар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


Дорнод аймгийн Дашбалбар сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр нэг хуудас хавсаргав.

Хувийг: Дашбалбар сумын Монгол ардын намд

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт: 1 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
БАЙГУУЛЛАГААС 2024 ОНЫ ОРОН НУТГИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Дорнод аймгийн Дашбалбар сумын Монгол Ардын намын хорооны Мөрийн хөтөлбөр нь:

1. Хүнээ дээдэлсэн нийгмийн хөгжлийг хангана.
2. Эрүүл аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.
3. Тогтвортой эдийн засагтай, тэргүүлэх хөгжилтэй сум болно гэсэн 3

үндсэн зорилтод тулгуурлан тодорхойлж боловсрууллаа.

Бид Хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

Бид Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж хүүхэд, багш, ажилтан нэг бүрийн хөгжлийг дэмжинэ.

Бид Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхийг эрмэлзэнэ.

Бид Хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулж экологийн тэнцвэрт байдлыг хадгална.

Бид Иргэдийн суурь хэрэгцээг бүрэн хангасан амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн сум хөгжүүлнэ.

Бид Байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй, дэвшилтэт технологид суурилсан газар тариаланг хөгжүүлнэ.

Бид Байгаль, түүх, соёлын нөөцдөө тулгуурлан гадаад болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Бид Орон нутгийн засаглалын чадавхийг бэхжүүлж, төрийн байгууллагуудын ажлын уялдааг сайжруулна.

1. ХҮНЭЭ ДЭЭДЭЛСЭН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙГ ХАНГАНА зорилтын хүрээнд.

1.1. Бид Орон нутгийн засаглалын чадавхийг бэхжүүлж, төрийн байгууллагуудын ажлын уялдааг сайжруулна.

- ✓ Мэдлэг чадвар, туршлагатай ахмад мэргэжилтэн бүхий зөвлөхүүдийн холбоог бүх салбарт байгуулж, дунд болон залуу үедээ зөвлөгөө, туршлагаасаа хуваалцах бололцоог бүрдүүлнэ.
- ✓ Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байдлаар иргэдэд шуурхай хүргэж, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- ✓ Төрийн захиргааны байгууллагуудын орчны тохижилтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байхаар тохижуулж тэднийг нийгмийн харилцаанд бусадтай адил тэгш оролцох боломжийг хангана.
- ✓ Төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлнэ./Сумын төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- ✓ Төрийн албан хаагчдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ./Сумын төсөвийн хөрөнгө оруулалтаар/

1.2. Бид Хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадуудын хөдөлмөр эрхлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
- ✓ Сумын эрүүл мэндийн үйлчилгээний стандартын түвшинг хангасан суурь орчинг бүрдүүлнэ.
- ✓ Ерөнхий боловсролын сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- ✓ Өсвөр насны хүүхдийг амьдрах ухаанд сургаж төлөвшүүлэх зорилготой хөдөлмөр амралтын зусланг суманд байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- ✓ Залуу гэр бүлийг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллана.

1.3. Бид. Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж хүүхэд, багш, ажилтан нэг бүрийн хөгжлийг дэмжинэ.

- ✓ Сургуулийн дотуур байр, цэцэрлэгийн хүрэлцээг нэмэгдүүлнэ.
- ✓ Сургууль, цэцэрлэгүүдэд “Сургуулийн бүс”, “Цэцэрлэгийн бүс” төсөл хэрэгжүүлнэ.
- ✓ Багш нарыг дотоод, гадаадад сургах, туршлага судлах ажлыг дэмжинэ.
- ✓ Ахлах сургуулийн барилга шинээр барих ажлыг улсын төсөвт тусгуулна. /Улсын төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- ✓ Бага сургуулийн өргөтгөлийн барилга шинээр барина./Улсын төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- ✓ Сургуулийн дотуур байранд их засвар хийнэ./Сумын төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- ✓ 150 хүүхдийн багтамжтай хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барина. /Улсын төсөвийн хөрөнгө оруулалтаар/

1.4 Бид Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхийг эрмэлзэнэ.

- ✓ Сумын иргэдийн амьдралын түвшинд мониторинг хийж, өрх гэрийн судалгаанд суурилсан амьжиргааны түвшний нэгдсэн мэдээллийн санг үүсгэнэ.
- ✓ Хүнсний ногооны хэрэгцээг дотоодоос бүрэн хангахад бодлогоор дэмжиж, хөрөнгө оруулалтыг чиглүүлнэ.
- ✓ Орлого багатай иргэдийг малжуулах, төмс хүнсний ногоо тариалахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- ✓ Жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийг оновчтой ил тод байдлаар зохион байгуулна.

2. ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ зорилтын хүрээнд.

2.1. Бид Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална.

- ✓ Төв, суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, орчны тоосжилт, агаарын хуурайшилтыг бууруулна.
- ✓ Хог хаягдлыг боловсруулах, дахин ашиглах үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- ✓ Газрын тос, уул уурхай, хайгуул, олборлолтын компаниудад байнгын хяналт-шинжилгээ хийж, орчны бохирдлоос сэргийлнэ.
- ✓ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бодлого”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.2. Бид Иргэдийн суурь хэрэгцээг бүрэн хангасан, амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн хот сууринг хөгжүүлнэ.

- ✓ Суманд хувийн орон сууц барих иргэн, аж ахуй нэгжид газар олголт, инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг дэмжиж ажиллана.
- ✓ Сумын төвийн хаягжуулалт, тэмдэглэгээг нэгдсэн стандартаар хийж тодотгоно.
- ✓ Мардайгаас сумын төв хүртэл 75 км замыг сайжруулсан_ шороон автазам барина./Аймгийн төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- ✓ Сумын төвийн 5 км замыг асфальтиар хучих ажлыг хийнэ./Аймгийн төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- ✓ Сумын төвийн хороололуудад хүүхдийн тоглоомын талбай шинээр барина./Сумын төсөвийн хөрөнгө оруулалтаар/

III. ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГТАЙ, ТЭРГҮҮЛЭХ ХӨГЖИЛТЭЙ СУМ БОЛНО зорилтын хүрээнд

Бид Хөдөө Аж Ахуйн үйлдвэрлэл, шинэ технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

- ✓ Суманд бэлчээрийн болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, үхэр-хонины аж ахуйг түлхүү хөгжүүлэх бодлого баримтална.
- ✓ Бэлчээрийн усан хангамжийг жил бүр нэмэгдүүлнэ.
- ✓ Хоршоо, фермерийн аж ахуйг хөгжүүлж, хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах боломжийг бүрдүүлнэ.
- ✓ Малчдын нийгмийн баталгааг хангах, залуучууд, залуу гэр бүлийг мал аж ахуйн салбарт ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- ✓ Мал эмнэлэгийн эмчилгээ үйлчилгээний хөлсийг зах зээлийн ханштай уялдуулан тухай бүрт тогтоож байна.

Сумын хөгжил багаас

- Баг бүрт жижиг, дунд үйлдвэрлэл байгуулах санал санаачлагыг дэмжинэ.
- Суманд талх, нарийн боов, сүү цагаан идээ, мах махан бүтээгдэхүүн боловсруулдаг жижиг үйлдвэр, цехийг зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэн оновчтой хэлбэрээр байгуулан ажиллуулахыг дэмжинэ.
- Малжуулах төслийг илүү боловсронгуй болгон хэрэгжүүлнэ.
- Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, шаардлагатай цэгт инженерийн шийдэлтэй худаг байгуулна./Сумын төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- Мал эмнэлгийн тасагыг бэхжүүлж, мал сүргийг эрүүлжүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.
- Наадмын талбайг шинээр барина./Сумын төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- Ахуйн үйлчилгээний төв байгуулна./Аймгийн төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- 400 хүний суудалтай соёлын төвийн барилга шинээр барина./Улсын төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- Буриад судлалын төв музей, номын сангийн барилгын дотор дэглэлт, тохижилтын ажлыг хийнэ./Сумын төсөвийн хөрөнгө оруулалтаар/
- Махны үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгөөр байгуулахыг дэмжинэ.
- Залуус хорооллын барилгыг үргэлжлүүлнэ.
- Сумын төвийн айл өрхийг ангилан ялгах хогийн савтай болгох./Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар/



ДАШБАЛБАР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО